2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,411,545.87
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	6,631,170.00
210202	1.1.1.2.1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	38,220.00
210203	1.1.1.2.1.1.2.3 ҮОМШӨ-ний даатгал	57,330.00
210205	1.1.1.2.1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	1,684,825.87
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,623,400.00
210301	1.1.1.2.1.1.3.1 Гэрэл, цахилгаан	16,623,400.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	18,690,000.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,690,000.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	77,104,000.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	77,104,000.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	520,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	520,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	196,248.53
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(196,248.53)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(196,248.53)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг “Орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлэх, лифтний ашиглалт, засвар үйлчилгээг гэрээгээр хариуцах, үйлдвэрлэлийн цехийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтний магадлал туршилтын ажлыг гүйцэтгэх орон нутгийн шинэчлэгдэж буй лифтний зураг төсөв боловсруулах захиалагчийн хяналт хийх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургах зэргээр иргэд оршин суугчдын аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, шинэ техник технологи нэвтрүүлэх төсөл боловсруулж, хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Тайлант онд тус газар нь “Иргэд, оршин суугчдын цахилгаан шатаар аюулгүй, найдвартай зорчих нөхцөлөөр хангах” зорилго дэвшүүлэн дараах зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. Үүнд:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж буй орон сууцны цахилгаан шатны захиалагчийн хяналт хийх;
- Нийслэл хотын гүүрэн гарцын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах;
- Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 сарын 07-ний өдрийн 03 дугаар “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 9-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт орсон;
- 2025 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн Монгол Улсын төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд албан хэргээ кирилл болон үндэсний монгол бичгээр хослуулан хөтөлж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ нь захирлын 2021 оны А/34 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,076.1 мянган төгрөгөөр буюу 1.36 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	465,512.81	458,505.88	(7,006.94)
Дансны авлага	1,554.00	-	(1,554.00)
Бараа материал	41,944.22	21,506.90	(20,437.32)
Үндсэн хөрөнгө	133,240.80	171,555.19	38,314.38
Биет бус хөрөнгө	17,033.82	16,793.82	(240.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	659,285.65	668,361.77	9,076.13
Өр төлбөрийн дүн	492,795.10	468,048.00	(24,747.10)
Эздийн өмчийн дүн	166,490.55	200,313.78	33,823.23
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	659,285.65	668,361.77	9,076.13

Дээрх хүснэгтээс харахад: өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснуудад байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 458,505.9 мянган төгрөг болж 7,007.0 мянган төгрөгөөр буурсан нь орон сууцны цахилгаан шатны шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийн хяналтын барьцаа төлбөрийг дансанд байршуулсантай холбоотой.

Авлагын дансны үлдэгдэл нь 1,554.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны Сууц өмчлөгчдийн холбооноос авах төлбөрт үйлчилгээний авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 21,506.9 мянган төгрөг болж 20,437.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд Өсөх Амжилт Эрдэнэ ХХК-аас 72,785.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн материалыг харьцуулалтын аргаар, байгууллагын хэрэгцээнд 11,819.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,527.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 100,513.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас;

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 171,555.2 мянган төгрөг болж 38,314.4 мянган төгрөгөөр өссөн нь 14,760.8 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авч, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны 1/1931 дугаарт албан бичгээр ирсэн машин, тоног төхөөрөмж хүлээлцэх актын дагуу нийт 33,704.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн 9 ширхэг компьютер, машин тоног төхөөрөмжийг орлогод авч, Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Ашид билгүүн Хөрөнгө үнэлгээний компаниар үлдэх өртөггүй болсон 22,150.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,307.7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг нийт 26,458.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар 11,575.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 28,738.5 мянган төгрөгийн тайлант хугацааны хуримтлагдсан элэгдэл бүртгэснээс;

Биет бус хөрөнгө 16,793.8 мянган төгрөг болж 240.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хуримтлагдсан элэгдэл бүртгэснээс;

Өр төлбөрийн үлдэгдэл 468,048.0 мянган төгрөг болж 24,747.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэлийн баталгаа 458,505.9 мянган төгрөгийг байршуулж, 45.6 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, нэмэгдсэн өртгийн татварын 9,496.5 мянган төгрөгийн өрийг барагдуулаагүйгээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын дарга нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 592,635.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 195,376.0 мянган төгрөгнийг 788,011.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 67,327.7 мянган төгрөгөөр бууруулж, 720,683.8 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 500,683.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 220,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 412,967.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 348,868.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаандаа 632,967.2 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 128,868.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 632,967.2 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь цалин хөлстэй холбоотой зардлыг 55,041.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,996.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 3,118.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 22,201.7 мянган төгрөг, бусад зардлуудыг 3,358.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 245,378.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс цалин хөлсний зардалд 123,832.8 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 8,411.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16,623.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 18,690.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 77,104.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 520.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/ Гүйцэтгэл
70708	Хөтөлбөр арга хэмжээ	245,378.00
81102	Бараа үйлчилгээний зардал	520.00
82206	Урсгал зардал	244,858.00

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 88 дугаар тогтоолоор Хоолны мөнгө 32.0 мянган төгрөгөөр, Унааны мөнгө 3.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

- Санхүүгийн тооцоолох группын Aculous accounting 4.0 програм хангамжийг 2012 оноос эхлэн нягтлан бодох бүртгэлийг хөтлөж байна. Тайлант жилд засвар сайжруулалтын хөлсөнд 450.0 мянган төгрөг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны бүртгэл

Тайлангийн хугацаанд Өсөх Амжилт Эрдэнэ ХХК-с 14,760.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 72,785.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн материалыг харьцуулалтын аргаар худалдан авч, үйл ажиллагааны орлогоор 2,550.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,341.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 3,876.4 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 2,051.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Уранчимэг, аудиторын туслах Э.Нандин-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Р.Алтанцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер С.Гантөгс, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн нийт зардлын 6,128,517.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 61,285.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 16,623.4 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-т “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.5-т “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг байршуулаагүй зөрчилийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлжээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар бусад хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 2,197.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлж 2,197.8 мянган зөрчлийг арилгаж, шийдвэрийг хэрэгжүүлсэн тул 2,197.8 мянган төгрөгийн зөрчлийг залруулгаар тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 609,743.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлжээ. Зөвлөмжийн хэрэгжилт 87.7 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	609,743.0	3	585,662.4	87.7
Нийт дүн	4	609,743.0	3	585,662.4	87.7

Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Захиалгын хүсэлт илгээхэд нэг байгууллага саналаа ирүүлсэн ч тухайн байгууллагаас худалдан авах бараа материал нь байгаагүй гэсэн шалтгаанаар цахим дэлгүүрээс худалдан авалт хийлгүй шууд худалдан авалт хийж зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах үйл ажиллагаа болон ажил үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллаж байгаа эсэхэд дараагийн тайлант хугацаанд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60.752.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 60,752.6 мянган төгрөгийн алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд Үндсэн үйл ажиллагааны орлогыг 60,752.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын сатандарт 1 болон санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулав.

Нийт илрүүлсэн зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,304.6 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт 1: Өмнөх оны аудитын 49,080.6 мянган төгрөгийн /захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх/ зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ 25,000.0 мянган төгрөгийн биелэлтийг хангаж, 24,080.6 мянган төгрөгийн худалдан авалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.3-т “Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөв.

5.3 ЗӨВЛӨМЖ

Илрүүлэлт 1: Санхүүгийн тайланд тусгагдсан өр төлбөр, авлагын журнал, тооцоо нийлсэн акттай тулгахад 9,496.5 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гарахаас өмнө өр төлбөр, авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулж байх.

Илрүүлэлт 2: Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт борлуулалтын орлогын дүнг Ерөнхий журналд тусгасан нийт борлуулалтын орлогын дүнтэй тулгахад ерөнхий журналд 9,403.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим төлбөрийн системд шивсэн борлуулалтын орлогын дүнг харилцах дансаар орж ирсэн орлогын дүнтэй тулгаж бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд Үндсэн үйл ажиллагааны орлогыг 60,752.6 мянган төгрөгөөр дууу тайлагнасан байгаа нь НББОУС-1 болон санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулав.	1	60,752.6	1	60,752.6			1	60,752.6		
Дүн	1	60,752.6	1	60,752.6			1	60,752.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчл		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд тусгагдсан ер төлбөр, авлагын журнал, тооцоо нийлсэн акттай тулгахад авлага 9,496.5 мянган төгрөг зөрүүтэй байна.	1	9,496.5					1	9,496.5				
Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт борлуулалтын дүн, Ерөнхий журналд тусгасан нийт борлуулалтын дүн 9,403.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	9,403.5					1	9,403.5				
Өмнөх оны аудитын /захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх/ зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	24,080.6			1	24,080.6						
Дүн	3	42,980.6			1	24,080.6			2	18,900.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлалтын 16,623.4 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	16,623.4			1	16,623.4		
Дүн	1	16,623.4			1	16,623.4		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 535/1001/0113

Улаанбаатар хот

НТАГ-2026/061/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн /захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх/ зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитын захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх/ зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын дарга (Д.Ган-Эрдэнэ), Нягтлан бодогч (Б.Уянга) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭИ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС
Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090957



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 534/10210493

Улаанбаатар хот

НТАГ-2026/061/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд байршуулах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16,623,400.00 /Арван зургаан сая зургаан зуун хорин гурван мянга дөрвөн зуу/ төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын дарга (Д.Ган-Эрдэнэ), Нягтлан бодогч (Б.Уянга) нарт даалгав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090959